

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн "Чандмань илч" ОНӨХХК-ийн
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2024/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Дорноговь аймаг

Сайншанд сум

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор:

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас: 70523020

Аудитор:

Т.Ган-Өлзий

Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

У.Оюунтүлхүүр

Цахим хаяг: oyuntulkuur.u@audit.gov.mn

Д.Дэмбэрэлсүрэн

Цахим хаяг: demberelsurend@audit.gov.mn

Б.Ариунбаатар

Цахим хаяг: ariunbaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайшланд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: domogovi@audit.gov.mn

2024-03-15 № 1-6/292

танай _____-ны № _____-т

ЧАНДМАНЬ-ИЛЧ ОНӨХХК-ИЙН
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭБЯАР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Чандмань-Илч" ОНӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань-Илч ОНӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус компанийн чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Ерөнхий журналыг шалгахад 221.8 сая төгрөгийн зардлыг тооцоо үүсгэлгүй шууд зардалд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Тайлант хугацаанд тус байгууллага нь ТБОНӨБАУХА тухай хуулийг мөрдөж ажиллаагүй, батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 71.4 сая төгрөгийн Нарны станцын систем угсралт суурьлуулалтын ажлыг ХАА зохион байгуулахгүйгээр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах...", ТБОНӨБАУХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8

010020075

дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Байгууллагын өглөг, авлагыг тооцоо нийлсэн акттай тулгахад 12 байгууллагын 19,277.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй" гэсэн заалтыг хэрэгжүүлж өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ Т.ГАН-ӨЛЗИЙ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	591,983,097.44	834,888,852.14
1.1.2	Дансны авлага	836,773,000.23	1,093,874,917.02
1.1.4	Бусад авлага	156,782,514.86	18,285,813.12
1.1.6	Бараа материал	1,722,374,486.62	1,014,121,899.16
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,811,584,684.24	10,400,537,184.10
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	8,119,497,783.39	13,361,708,665.54
1.2.1	Үндсэн хөрөнгө	27,648,985,558.27	30,323,939,084.45
1.2.2	Биет бус хөрөнгө	2,673,655,420.82	2,630,538,917.36
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	30,322,640,979.09	32,954,478,001.81
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	38,442,138,762.48	46,316,186,667.35
2.1.1.1	Дансны өглөг	628,841,983.22	1,017,705,379.10
2.1.1.3	Татварын өр	176,489,647.83	144,408,863.30
2.1.1.4	НДШ-ийн өр	222,938.68	87,945,374.37
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	999,998,612.59
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	5,821,414,774.25	10,380,585,585.92
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,626,969,343.98	12,630,643,815.28
2.1.2.1	Урт хугацаат зээл	1,918,465,293.49	1,918,465,293.49
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	14,284,627,217.63	17,987,970,279.45
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	16,203,092,511.12	19,906,435,572.94
2.2	Өр төлбөрийн нийт дүн	22,830,061,855.10	32,537,079,388.22
2.3.1	Өмч - төрийн	15,459,856,685.46	15,459,856,685.46
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,388,629,707.44	7,388,629,707.44
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	521,700,701.20	521,700,701.20
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-7,758,110,186.72	-9,591,079,814.97
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-1,832,969,628.25
2.3.9.2	Хуримтлагдсан ашиг	-7,758,110,186.72	-7,758,110,186.72
2.3.11	Эздийн өмчийн нийт дүн	15,612,076,907.38	13,779,107,279.13
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	38,442,138,762.48	46,316,186,667.35

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	10,283,871,765.78	11,799,001,183.71
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	11,269,534,972.13	13,283,729,024.82
3	Нийт ашиг (алдагдал)	-985,663,206.35	-1,484,727,841.11
4	Түрээсийн орлого	12,435,272.71	19,284,727.22
5	Хүүний орлого	-	495,589.18
8	Бусад орлого	-	2,323,516.00
8.1	Орлогын дүн	12,435,272.71	22,103,832.40
9	Борлуулалт, маркетингийн зардал	163,775,864.55	187,091,884.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	775,614,670.90	890,535,221.86
12	Бусад зардал	270,558,288.32	172,971,789.39
12.1	Зардлын дүн	1,209,948,823.77	1,250,598,895.25
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	2,261,834.00	-2,387,250.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-169,928,807.85	-
17	Бусад ашиг (алдагдал)	758,842,487.61	882,640,525.71
17.1	Олз гарзны дүн	591,175,513.76	880,253,275.71
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-1,592,001,243.65	-1,832,969,628.25
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,592,001,243.65	-1,832,969,628.25
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	-1,592,001,243.65	-1,832,969,628.25

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,459,856,685.46	7,731,578,024.44	-6,495,527,147.96	17,208,517,263.14
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	329,418,204.89	329,418,204.89
3	Залруулсан үлдэгдэл	15,459,856,685.46	7,731,578,024.44	-6,166,108,943.07	17,537,935,468.03
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-1,592,001,243.65	-1,592,001,243.65
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	9,091,000.00
6	Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-342,948,317.00	-	-342,948,317.00
7	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,459,856,685.46	7,388,629,707.44	-7,758,110,186.72	15,612,076,907.38
8	Залруулсан үлдэгдэл	15,459,856,685.46	7,388,629,707.44	-7,758,110,186.72	15,612,076,907.38
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-1,832,969,628.25	-1,832,969,628.25
10	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,459,856,685.46	7,388,629,707.44	-9,591,079,814.97	13,779,107,279.13

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		01-р сарын 01	12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,286,774,982.73	18,705,528,705.43
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,711,620,498.73	17,302,933,077.10
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	242,622.00	10,079,627.10
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	116,348.00
1.1.5	Татаас, санхүүжилтын орлого	1,553,131,938.00	1,308,970,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	21,779,924.00	83,429,653.23
1.2	Мөнгөн зарлага (-)	19,223,234,852.05	19,315,148,904.43
1.2.1	Ажиллагчдад төлсөн	5,143,542,918.72	4,560,194,340.58
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	1,123,882,177.71	1,219,106,485.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	7,297,745,055.72	7,871,354,667.12
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,335,683,625.07	1,775,857,262.03
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,382,320,021.20	1,213,559,667.60
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	6,605,424.67	4,444,302.28
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,127,819,552.61	1,196,666,225.29
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	11,534,608.86	17,682,885.28
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,794,101,467.49	1,456,283,068.58
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,063,540,130.68	-609,620,199.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	2,514,870.15
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	2,514,870.15
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	2,514,870.15
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	1,000,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	1,000,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,008,798,903.68	149,988,916.45
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,008,798,903.68	149,988,916.45
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,008,798,903.68	850,011,083.55

Дорноговь аймгийн "Чандмань-Илч" ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	54,741,227.00	242,905,754.70
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	537,241,870.44	591,983,097.44
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	591,983,097.44	834,888,852.14

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт: Дулаан үйлдвэрлэлт	Гкал	61,000.00	75,000.00	-14,000.00	123%
	Цэвэр ус олборлолт	м3	540,000.00	612,000.00	-72,000.00	113%
	Бохир ус татан зайлуулалт	м3	432,000.00	489,600.00	-57,600.00	113%
2	Нийт орлого	төгрөг	11,004,037,848.00	12,701,358,288.00	1,697,320,440.00	115%
	Үүнээс: Цэвэр борлуулалт	төгрөг	10,356,086,264.00	11,214,169,817.00	-858,083,553.00	108%
	Бусад орлого /алданги торгуулийн засвар үйлчилгээний орлогууд/	төгрөг	747,951,581.00	1,487,188,475.00	-739,236,894.00	199%
3	Нийт зардал	төгрөг	14,557,603,961.00	14,534,328,069.00	23,275,892.00	100%
	Үүнээс: Удирдлагын зардал	төгрөг	1,164,608,316.00	1,162,746,245.00	1,862,071.00	100%
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	төгрөг	(3,553,566,110.0)	(1,832,969,652.0)	1,720,596,458.00	52%
5	Улсын төсвийн татаас	төгрөг	0	0	0.00	-
6	Цэвэр ашиг, алдагдал	төгрөг	(3,553,566,110.00)	(1,832,969,652.00)	1,720,596,458.00	52%
7	Төсвийн төлбөрт нийт дүн	төгрөг			0.00	-
8	Төрийн өмчийн ногдол ашигт	төгрөг		0	0.00	-
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	383	318	65.00	83%
10	Нийт цалингийн сан	төгрөг	5,455,890,470.00	4,682,587,700.00	773,302,770.00	86%
11	Нэг ажиллагчийн дундаж цалин	төгрөг	1,734,530.00	1,901,239.00	-166,709.00	110%
12	Нэгж бүтээгдэхүүний өртөг- Дулаан	төг/Гкал		135,653.00	-135,653.00	-
	Нэгж бүтээгдэхүүний өртөг-Цэвэр ус	төг/м.куб		7,124.00	-7,124.00	-
	Нэгж бүтээгдэхүүний өртөг-Бохир ус	төг/м.куб		5,699.20	-5,699.20	-
13	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг		1.75	-1.75	-
14	Хөрөнгө оруулалт	төгрөг		376,173.00	-376,173.00	-
15	Нийт авлага	төгрөг	836,773,250.00	1,094,439,512.00	-257,666,262.00	131%
16	Нийт өглөг	төгрөг	628,383,500.00	1,017,705,300.00	-389,321,800.00	162%
	Үүнээс: Богино хугацаат	төгрөг		1,000,000,000.00	1,000,000,000.00	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 564.6 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад 564.6 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Тус байгууллага нь тайлант хугацааны эцэст Хаан банкны харилцах дансны 564,600 төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Аудитаар нийт 3 зөрчил² илэрснээс, 312.522.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

Ерөнхий журналыг шалгахад 221.8 сая төгрөгийн зардлыг тооцоо үүсгэлгүй шууд зардалд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Тайлант хугацаанд тус байгууллага нь ТБОНӨБАҮХА тухай хуулийг мөрдөж ажиллаагүй, батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 71.4 сая төгрөгийн Нарны станцын систем угсралт суурьлуулалтын ажлыг ХАА зохион байгуулахгүйгээр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2-т “төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах ...”, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

3. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Байгууллагын өглөг, авлагыг тооцоо нийлсэн акттай тулгахад 12 байгууллагын 19,277.0 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Ерөнхий нягтлан бодогч нь эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэгтэй” гэсэн заалтыг хэрэгжүүлж өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Харилцах дансны үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	264.6	1	264.6			1	264.6				
Дүн	1	264.6	1	264.6			1	264.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зардлыг тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэсэн байна	1	221,845.7			1	221,845.7						
Өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуул аагүй	1	19,277.0			1	19,277.0						
Дүн	2	241,122.7			2	241,122.7						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ТБОНӨХБАУХА тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй	1	71,400.0					1	71,400.0				
Дүн	1	71,400.0					1	71,400.0				
Нийт дүн	1	312,522.7					1	312,522.7				